



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/27

Улаанбаатар хот

Дотоод удирдлагын систем ашиглалтын
байдлыг сайжруулах арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.16, Хөдөлмөрийн тухай хуулийн 90.2, 90.3, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/1054 дүгээр захирамж, Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2023 оны 06 дугаар хурлын тэмдэглэл, Газрын дүрмийн 7.1.1, 7.1.8, Хөдөлмөрийн дотоод журмын 5 дугаар бүлгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын ERP систем (www.erp.ulaanbaatar.mn) ашиглалтыг сайжруулах арга хэмжээний удирдамжийг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан удирдамжийн дагуу “Ажлын хэсэг, Хурал уулзалт, Үүрэг даалгавар”, “Ажил төлөвлөлт”, “Цаг бүртгэл” дэд систем ашиглалтыг сайжруулж ажиллахыг нийт хэлтэс, албан хаагчдад үүрэг болгосугай.

3. Удирдамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Э.Даваахатан)-т даалгасугай.

ДАРГА



С.ТӨМӨРДУЛАМ